



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2021 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 443

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,  
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Мэргэжлийн хяналтын ерөнхий газар болон харьяа байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 4 нэрийн 252,347,021.01 (хоёр зуун тавин хоёр сая гурван зуун дөчин долоон мянга хорин нэгэн төгрөг нэг мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн цаашид ашиглаж болох хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг нийт 150,090,000.00 (нэг зуун тавин сая ерэн мянга) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Т.Гантулга, Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга Н.Бямбадорж нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001351

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2021 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн  
22 дугаар тогтоолын хавсралт



**Мэргэжлийн хяналтын ерөнхий газар болон харьяа байгууллагын үндсэн хөрөнгөд  
бүртгэлтэй үлдэх өртөггүй, хөрөнгийн ашиглалтын  
хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоох хөрөнгийн жагсаалт**

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалта д орсон огноо	Тоо хэмжээ	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл	Шинэчлэн тогтоох нэг бүрийн үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоох нийт үнэ (төгрөг)	Цаашид ашиглах жил
<b>Мэргэжлийн хяналтын ерөнхий газар</b>							
1	Ланд круйзер 200, улсын дугаар 06-38 УБЗ	7/17/2014	1	174,400,000.00	90,000,000.00	90,000,000.00	5
2	Ланд круйзер 200 VGR, улсын дугаар 01-83 УНУ	10/29/2010	1	74,089,021.01	60,000,000.00	60,000,000.00	5
<b>Баянхонгор аймгийн мэргэжлийн хяналтын газар</b>							
3	Автоклав 40л	10/6/2010	1	2,558,000.00	60,000.00	60,000.00	1
4	РС микроскоп	4/1/2010	1	1,300,000.00	30,000.00	30,000.00	2
	<b>Нийт дүн</b>		<b>4</b>	<b>252,347,021.01</b>		<b>150,090,000.00</b>	

--- о о ---